

УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Увс аймгийн Тэс сумын Таван тэсийн илч ОНӨААТҮГ-ын 2022 оны санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: УВА-2023/08/НА-СТА-ОНА

Цахим хуудас:
www.audit.mn
Улаангом хот
2023 он

Увс аймаг дахь Төрийн аудитын газар,
Дарга, тэргүүлэх аудитор: М.Батсуурь
Утас: 70453317, Цахим хаяг: BatsuuriM@audit.gov.mn
Аудитын менежер: М.Бат-Амгалан
Утас: 70453799, Цахим хаяг: Bat-Amqalanm@audit.gov.mn
Гэрээгээр аудитыг гүйцэтгэсэн Баян жанжин хишиг аудит
ХХК аудитор: А.Дугармаа
Утас: 99542180, Цахим хаяг: baynjanjinxishig@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....
 - 3.1 Компани, түүний үйл ажиллагаа
 - 3.2 Компанийн гадаад, дотоод орчин.....
 - 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....
 - 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад гарсан өөрчлөлт
4. Аудитын тайлан

 - 4.1 Ерөнхий зүйл
 - 4.2 Материаллаг байдал
 - 4.3 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал
 - 4.4 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт
 - 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
 - 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....

5. Аудитын илрүүлэлт
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл.....

Товчилсон үгийн жагсаалт

СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2021 оны 12-р сарын 31	2022 оны 12-р сарын 31
1	ХӨРӨНГӨ		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	60,108,790.52	72,421,391.94
1.1.2	Дансны авлага	34,885,407.81	52,183,318.34
1.1.3	Татвар, НДШ – ийн авлага		
1.1.4	Бусад авлага	476,778.00	413,843.94
1.1.5	Бусад санхүүгийн хөрөнгө		
1.1.6	Бараа материал	12,112,227.51	23,168,630.24
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо		
1.1.8	Бусад эргэлтийн хөрөнгө		
1.1.9	Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө)		
1.1.10			
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	107,583,203.84	148,187,184.46
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө	3,034,682,175.03	2,906,455,334.74
1.2.2	Биет бус хөрөнгө		
1.2.3	Биологийн хөрөнгө		
1.2.4	Урт хугацаат хөрөнгө оруулалт		
1.2.5	Хайгуул ба үнэлгээний хөрөнгө		
1.2.6	Хойшлогдсон татварын хөрөнгө		
1.2.7	Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө		
1.2.8	Бусад эргэлтийн бус хөрөнгө		
1.2.9			
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	3,034,682,175.03	2,906,455,334.74
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	3,142,265,378.88	3,054,642,519.20
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
2.1	Өр төлбөр		
2.1.1	Богино хугацаат өр төлбөр		
2.1.1.1	Дансны өглөг	9,261,720.00	364,200.00
2.1.1.2	Цалингийн өглөг	42,079.43	1,055,787.37
2.1.1.3	Татварын өр	18,428,004.27	11,052,527.18
2.1.1.4	НДШ – ийн өглөг	806,406.47	547,314.35
2.1.1.5	Богино хугацаат зээл		
2.1.1.6	Хүүгийн өглөг		
2.1.1.7	Ногдол ашгийн өглөг		
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	250,534.00	561,279.66
2.1.1.9	Нөөц/өр төлбөр/		
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	192,125.99	77,191.95
2.1.1.11	Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө) - нд хамаарах өр төлбөр		
2.1.1.12			
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	28,980,870.16	13,658,300.52
2.1.2	Урт хугацаат өр төлбөр		
2.1.2.1	Урт хугацаат зээл		
2.1.2.2	Нөөц /өр төлбөр/		

2.1.2.3	Хойшлогдсон татварын өр		
2.1.2.4	Бусад урт хугацаат өр төлбөр		
2.1.2.5			
2.1.2.6	Урт хугацаат өр төлбөрийн дүн		
2.2	Өр төлбөрийн нийт дүн	28,980,870.16	13,658,300.52
2.3	Эздийн өмч		
2.3.1	Өмч-төрийн	3,938,946,084.44	3,938,946,084.44
2.3.2	хувийн		
2.3.3	хувьцаат		
2.3.4	Халаасны хувьцаа		
2.3.5	Нэмж төлөгдсөн капитал		
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	49,261,114.00	49,261,114.00
2.3.7	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц		
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг		
2.3.9	Хуримтлагдсан ашиг	-874,922,689.73	-947,222,979.76
2.3.10			
2.3.11	Эздийн өмчийн дүн	3,113,284,508.71	3,040,984,218.68
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	3,142,265,378.88	3,054,642,519.20

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тэмцэн

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2021 оны 12-р сарын 31	2022 оны 12-р сарын 31
1	Борлуулалтын орлого (цэвэр)	338,187,513.63	476,789,351.82
2	Борлуулалтын өртөг	405,879,288.96	496,393,982.92
3	Нийт ашиг(алдагдал)	-67,691,775.33	-19,604,631.10
4	Түрээсийн орлого		
5	Хүүгийн орлого		
6	Ногдол ашгийн орлого		
7	Эрхийн шимтгэлийн орлого		
8	Бусад орлого		547,263.00
9	Борлуулалт, маркетингийн зардал		
10	Ерөнхий ба удирдлагын зардал	75,687,803.07	52,182,822.37
11	Санхүүгийн зардал		
12	Бусад зардал	5,109,585.00	3,440,000.00
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)		
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		
15	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		
16	Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)		
17	Бусад ашиг (алдагдал)		
18	Татвар төлөхийн өмнөх ашиг(алдагдал)	-148,489,163.40	-74,680,190.47
19	Орлогын татварын зардал		
20	Татварын дараах ашиг (алдагдал)	-148,489,163.40	-74,680,190.47
21	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)		
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-148,489,163.40	-74,680,190.47
23	Бусад дэлгэрэнгүй орлого		
	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү		
	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү		
	Бусад олз (гарз)		
24	Орлогын нийт дүн	-148,489,163.40	-74,680,190.47

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	474,206,168.19	507,481,122.13
	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	473,826,168.19	507,481,122.13
	Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого		
	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө		
	Буцаан авсан албан татвар		
	Татаас, санхүүжилтийн орлого		
	Бусад мөнгөн орлого	380,000.00	
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	390,208,368.86	491,071,540.71
	Ажиллагчдад төлсөн	106,247,639.00	116,322,812.00
	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	33,195,655.19	35,747,861.47
	Бараа материал худалдан авахад төлсөн	155,709,104.00	250,501,200.00
	Ашиглалтын зардалд төлсөн	32,857,254.86	29,923,335.30
	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	6,660,300.00	7,508,045.00
	Хүүгийн төлбөрт төлсөн		
	Татварын байгууллагад төлсөн	33,947,890.81	36,769,042.94
	Даатгалын төлбөрт төлсөн		
	Бусад мөнгөн зарлага	21,590,525.00	14,299,244.00
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	83,997,799.33	16,409,581.42
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
2.1	Мөнгөн орлогын дүн (+)		62,940.00
	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого		
	Биет бус хөрөнгө борлуулсны орлого		
	Хөрөнгө оруулалт борлуулсны орлого		
	Бусад урт хугацаат хөрөнгө борлуулсны орлого		
	Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт		62,940.00
	Хүлээн авсан хүүгийн орлого		
	Хүлээн авсан ногдол ашиг		
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	432,308.00	4,038,840.00
	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	432,308.00	3,975,900.00
	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		
	Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн		
	Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		
	Бусдад олгосон зээл болон урьдчилгаа		62,940.00
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-432,308.00	-3,975,900.00
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
3.1	Мөнгөн орлогын дүн (+)		
	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан		
	Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан		
	Төрөл бүрийн хандив		
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	24,613,000.00	121,080.00
	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	24,613,000.00	121,080.00

25	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)		
----	--	--	--

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмч	Нэмж төлөгдсөн капитал	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
2021 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	3,938,946,084.44		49,261,114.00		-874,922,689.73	3,113,284,508.71
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга						
Залруулсан үлдэгдэл						
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)						
Өмчид гарсан өөрчлөлт						
Зарласан ногдол ашиг						
2021 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	3,938,946,084.44		49,261,114.00		-874,922,689.73	3,113,284,508.71
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга					2,379,900.44	2,379,900.44
Залруулсан үлдэгдэл	3,938,946,084.44		49,261,114.00		-872,542,789.29	3,115,664,409.15
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)					-74,680,190.47	-74,680,190.47
Өмчид гарсан өөрчлөлт						
Зарласан ногдол ашиг						
2022 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	3,938,946,084.44		49,261,114.00		-947,222,979.76	3,040,984,218.68

	Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн		
	Хувьцаа буцаан худалдаж авахад төлсөн		
	Төлсөн ногдол ашиг		
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-24,613,000.00	-121,080.00
	Валютын ханшийн зөрүү		
5	Бүтэцтэй мөнгөн гүйлгээ	58,952,491.33	12,312,601.42
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	1,156,299.19	60,108,790.52
7	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	60,108,790.52	72,421,391.94

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Увс аймгийн Таван тэсийн илч" ОНӨААТҮГ, түүний үйл ажиллагаа

Увс аймгийн Таван тэсийн илч" ОНӨААТҮГ-ийн зорилго, зорилт

Шинжлэх ухаан технологийн дэвшилд суурилсан, байгаль орчинд ээлтэй, зардал хэмнэсэн технологийг чадварлаг боловсон хүчинтэй хослуулан дулааны эрчим хүч үйлдвэрлэн Тэс сумын хэрэглэгчдийг тасралтгүй, найдвартай дулаан цэвэр усаар хангаж, компанийн ашиг орлогоо нэмэгдүүлэх дараах зорилготой үйл ажиллагаа явуулдаг. Үүнд:

1. Тэс сумын дулааны эрчим хүч хэрэглэгчдийн ачаалал, цаашдын өсөн нэмэгдэх хэрэгцээ, хэрэглэгчдийн байрлал, дулаан хангамжийн гол магистрал шугам явах зурвасын судалгаа хийж орон нутгийн удирдлагуудтай тохиролцож, баталгаажуулах.
2. Усан хангамж, дулаан хангамжийн гол (магистраль) шугам сүлжээ байгуулж хэрэглэгчдийг сүлжээнд холбож сүлжээ болон хэрэглэгчдийн бэлэн байдлыг шалгах.
3. Хүний нөөцийн менежментийн бодлогоо сайжруулж, ажиллагсдыг мэргэшүүлэн, цалингийн урамшууллын тогтолцоог нэвтрүүлэх замаар чадвартай, тогтвор суурьшилтай хамт олныг бүрдүүлэх.
4. Хэрэглэгчдэд чанарын шаардлага хангасан, тав тухтай байдлыг хангасан бүтээгдэхүүнээр үйлчилж компанийн ашиг орлогоо нэмэгдүүлэх.

Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээнд ОНӨААТҮГ гэсэн статустай байна. Өмчийг төр 100 хувийг эзэмшиж байна.

3.2 Увс аймгийн Таван тэсийн илч" ОНӨААТҮГ-ын гадаад, дотоод орчин

Тэс сумын Таван тэсийн илч ОНӨААТҮГ-ын Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн цалин, урамшууллыг 6,208.2 мянган төгрөгөөр тогтоосон нь ТБОНӨТХ-ийн 21 дүгээр зүйлийн 12 дахь заалт, Засгийн газрын 2016 оны 80 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэх журам"-ын 3.7-д "...цалин хөлсний хэмжээг тухайн хуулийн этгээдийн үйл ажиллагааны хүрээ, санхүү, эдийн засгийн байдлыг харгалзан Хувьцаа эзэмшигчдийн хурал тогтооно. Цалин хөлсний хэмжээ нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2 дахин нэмэгдүүлснээс ихгүй байна" гэсэн заалтай нийцэж байна.

Монгол Улсын Засгийн газрын "2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-ийн 4.4.10-т "Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл, ашиглалт, хамгаалалтыг сайжруулж, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн засаглалыг олон улсын жишигт нийцүүлэх, газрын хууль тогтоомжийг төрийн байгууламж нэгдмэл байх зарчим болон өмчийн эрх зүйд нийцүүлэн боловсронгуй болгоно" гэж заасан байна. Энэ хүрээнд хөрөнгө хадгалах хамгаалах арга хэмжээ авсан байна.

Засгийн газрын 2021 оны 43 дугаар "Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай" тогтоолын 1.3-д "Төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагын дотоод зохион байгуулалтын бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлж, орон тоо, чиг үүргийн давхардлыг арилгаж, төсөв, зардлыг хэмнэсэн байхаар шинэчлэх, удирдлагын цалин хөлсийг орлого, үр ашигтай нь уялдуулан, үйл ажиллагааны чиглэл, цар хүрээ, түвшин зэргийг харгалзан нэг хэлбэр, нийтлэг жишгээр ангилан тогтоодог зарчимд шилжих, цалин хөлсийг нэмэгдүүлэхгүй, шагнал, урамшуулал олгохгүй байх, зочин төлөөлөгч хүлээн авах, бэлэг дурсгал (цүнх, календарь, мэндчилгээ г.м)-ын зардлыг гаргахгүй байх"-д заасны дагуу дотоод зохион байгуулалтын бүтэц орон тоо өөрчлөлт ороогүй, удирдлагын цалин хөлсийг орлого, үр ашигтай нь уялдуулан тогтоосон байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Төсвийн тухай хуулийн нэмэлт өөрчлөлт
- Эрчим хүчний тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Засгийн газрын 2020 оны 11 дүгээр сарын 183 тоот "Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбогдуулан эдийн засгийг дэмжих чиглэлээр авах зарим арга хэмжээний тухай"
- Засгийн газрын 2020 оны 1 дүгээр сарын 10 тоот "Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах зарим арга хэмжээний тухай"
- Нийгмийн даатгалын тухай хуулийн шинэчлэл

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Тэс сумын Таван тэсийн илч ОНӨААТҮГ-ын 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад орсон өөрчлөлт

Тэс сумын Таван тэсийн илч ОНӨААТҮГ-ын 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалаар баталсан аж ахуйн нэгжид мөрдөгдөх "Санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 87,622.8 мянган төгрөгөөр буюу 2.8 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	60,108.7	72,421.3	12,312.6
Авлага	35,362.1	52,597.1	17,235.0
Бараа материал	12,112.2	23,168.6	11,056.4
Үндсэн хөрөнгө	3,034,682.1	2,906,455.3	-128,226.8
Нийт хөрөнгө	3,142,265.3	3,054,642.5	-87,622.8
Өр төлбөр	28,980.8	13,658.3	-15,322.0
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	3,113,284.5	3,040,984.2	-72,300.3
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	3,142,265.3	3,054,642.5	-87,622.8

Өмнөх оны үзүүлэлтээс мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн дансанд материаллаг өөрчлөлт гарсан байна. Тухайлбал:

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 72,421.3 мянган төгрөг болж 12,312.6 мянган төгрөгөөр өссөн нь борлуулалтын орлого байна.

Авлага дансны үлдэгдэл 52,597.1 мянган төгрөг болж 17,235.0 мянган төгрөгөөр өссөн нь хэрэглэгчээс дулаан борлуулсны авлага-байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 23,168.6 мянган төгрөг болж 11,056.4 мянган төгрөгөөр өссөн нь 2 зуух галлаж байгаатай холбоотойгоор нүүрс болон сэлбэг нөөцөлснөөс шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 2,906,455.3 мянган төгрөг болж 128,226.8 мянган төгрөгөөр буурсан нь хөрөнгийн элэгдлийн зардал өссөн нь шалтгаалжээ. Үндсэн хөрөнгийн дансанд 1,142.4 мянган төгрөгийн тавилга, 2,272.6 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж шинээр нэмэгдсэн байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 13,658.3 мянган төгрөг болж 15,322.0 мянган төгрөгөөр буурсан нь нүүрсний өр барагдуулснаас шалтгаалжээ.

Татварын НӨАТ 7,375.4 мянга, нийгмийн даатгалын шимтгэл 259.0 мянга, нүүрний 8,897.5 мянган төгрөгөөр өр төлбөр барагдуулсан байна.

Эздийн өмч дансны үлдэгдэл 3,040,984.2 мянган төгрөг болж 87,622.8 мянган төгрөгөөр буурсан нь хөрөнгийн элэгдлийн зардал шалтгаалжээ.

Өмнөх үеийн хуримтлагдсан ашиг (947,222.9) мянган төгрөг болж 72,300.2 мянган төгрөгөөр өссөн нь 2 зуух ажиллуулж байгаатай холбоотойгоор өртөг нэмэгдсэн нь шалтгаалжээ.

3.5 Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу Тэс сумын Таван тэсийн илч ОНӨААТҮГ-ын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны 01 дүгээр тогтоолоор Тэс сумын Таван тэсийн илч ОНӨААТҮГ-ын 2022 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг баталсан байна. Тайлант оны нийт орлогыг 515,287.7 мянган төгрөгөөр, нийт зардлыг 612,253.8 мянган төгрөгөөр, 96,966.1 мянган төгрөгийн ашиг /алдагдал/ байхаар тогтоосон байна. Үүнээс хөрөнгө оруулалтын арга хэмжээнд 13,247.0 мянган төгрөгийг төлөвлөсөн байна.

Гүйцэтгэлээр 477,336.6 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, 552,016.8 мянган төгрөгийн зардал гарган (74,680.1) төгрөгийн алдагдалтай ажилласан байна. Орлогын эх үүсвэр нь дулаан, цэвэр бохир усны орлогоос бүрджээ.

Нийт орлогын гүйцэтгэл 476,789.3 мянган төгрөг болж төлөвлөснөөс 38,498.4 мянган төгрөг буюу 8 хувиар тасарсан байна. Ундарга петролиум ХХК-с борлуулалтын авлага 34,480.0 төгрөг, бусад авлага нь айл өрх, аж ахуйн нэгжээс авах авлага орж ирээгүй шалтгаанаас голлон нөлөөлсөн байна.

Нийт зардлын гүйцэтгэл 552,016.8 мянган төгрөг болж, төлөвлөснөөс 60,237.0 мянган төгрөг буюу 9 хувиар дутуу гүйцэтгэлтэй байна.

Тайлант онд цэвэр алдагдал (74,680.1) мянган төгрөг болж, төлөвлөснөөс 22,286.1 мянган төгрөгөөр бага байгаа нь 22.9 хувиар зардал буурснаас шалтгаалж байна.

Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг үйлдвэрлэлийн үндсэн үзүүлэлт, орлого, зардлын зүйлс тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 3.4-д харуулав.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана" гэж заасны дагуу Тэс сумын Таван тэсийн илч ОНӨААТҮГ-ын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад Тэс сумын Таван тэсийн илч ОНӨААТҮГ-ын санхүүгийн тайлагналтай холбоотой залруулсан алдаа зөрчил, төлбөрийн акт, албан шаардлагыг тусгасан болно.

Аудитыг Баян жанжин хишиг аудит ХХК-ийн аудитор А.Дугармаа гүйцэтгэж, хяналтыг Увс аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер М.Бат-Амгалан, дарга, тэргүүлэх аудитор М.Батсуурь нар тус тус хэрэгжүүлсэн.

Тэс сумын Таван тэсийн илч ОНӨААТҮГ-ын 2022 оны санхүүгийн тайлан Баян жанжин хишиг аудит ХХК-д 2023 оны 02 дугаар сарын 13-ны өдрийн 07 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон материаллаг байдлыг 2022 оны санхүүгийн тайлангийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 496.3 сая төгрөгөөс 1 хувиар буюу 4.9 сая төгрөгөөр тогтоосон. Гүйцэтгэлийн шатанд материаллаг байдлыг 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 496.3 сая төгрөгийн 1 хувиар буюу 4.9 сая төгрөгөөр 80 хувиар тооцож 3.9 сая төгрөгөөр тогтоолоо.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил гараагүй болно. /АБ-4/

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд www.shilendans.gov.mn цахим хуудсанд оруулбал зохих 151 мэдээллээс байршуулах хугацаа болоогүй 2, хугацаандаа оруулсан 139, хугацаа хоцроож 10 мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд байршуулсан байна.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тэс сумын Таван тэсийн илч ОНӨААТҮГ нь Зөрчлийн утгыг оруулах Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 28.5 дахь хэсэгт "Татвар төлөгч борлуулалт хийх тухай бүрд хэрэглэгчийн системээс дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтыг хэвлэж өгөх, эсхүл цахимаар илгээх үүрэгтэй" гэж заасныг хэрэгжүүлэн ажиллаагүй байна.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Тэс сумын Таван тэсийн илч ОНӨААТҮГ-ын 2022 оны санхүүгийн тайланд завсрын аудит хийгээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар зөвлөмж өгөгдөөгүй байна.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Тэс сумын Таван тэсийн илч ОНӨААТҮГ-ын хувьд дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй болно.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар зөрчил илрээгүй болно.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

АУДИТЫН ТАЙЛАНГ

ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

БЭЛТГЭСЭН: БАЯН ЖАНЖИН ХИШИГ АУДИТ
ХХК-ийн АУДИТОР

/М.БАТСУУРЫ/

/М.БАТ-АМГАЛАН/

/А.ДУГАРМАА/

2023 оны 03 дугаар сарын 14-ний өдөр